

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ГУРАВ ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН
БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
ХОТ

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 21, 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.4-т заасны дагуу төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн, танилцуулгын хамт Та бүхэнд хүргүүлсэн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2027 онд 5.8 хувь, 2028 онд 6.0 хувь, 2029 онд 6.3 хувь байх, хэрэглээний үнийн өсөлтийн түвшнийг 2027 онд 7.0 хувь, 2028 онд 6.0 хувь, 2029 онд 5.0 хувь байхаар тооцсон. Мөн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 2027 онд 34,780.0 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 30.4 хувь, нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээг 2027 онд 36,493.4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 31.9 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2027 онд 1,713.4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.5 хувьтай тэнцэх, Засгийн газрын өрийн нийт хэмжээг 2027 онд 57,114.9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 50.0 хувьтай тэнцэхээр байна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Оюутолгой компанийн тайлантай холбогдуулан тус компани нь ноогдол ашиг хуваарилах боломжтой эсэх болон менежментийн төлбөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тооцоолсон инфляц нь бодит нөхцөлтэй харьцуулахад зөрүүтэй байгаа талаар дурдаж, 2029 онд инфляцыг 5.0 хувьд хүргэх боломж байгаа эсэх, томоохон орд газруудын төрд авах ноогдол ашиг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төсөөлөл, мөн төрийн худалдан авалттай холбоотой төсвийн хөрөнгө оруулалтын зардлын өсөлт болон үр өгөөжийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналгүй тул Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5-т заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагад нийцсэн эсэх талаарх дүгнэлт гаргаагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

